БАТЛАВ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ж.ЛХАГВАСҮРЭН

2024 оны 06 сарын 13 өдөр

# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН "5 ДУГААР ХОРОО 49/2 ДУГААР БАЙРНЫ ЛИФТ ЗАСВАРЫН АЖИЛ" -ЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ СУУРИЛУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 06 дугаар сарын 13 өдөр Дугаар..24 Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| 1. | Ажил гүйцэтгэх үндэслэл | • Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2023-2024 үйл ажиллагааны хөтөлбөр<br>• Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 30 дугаар тогтоол |
| 2. | Барилга байгууламжийн байршил | Лифт засварлах:<br>• Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо, 49/2 дугаар байр |
| 3. | Зориулалт, хүчин чадал | • Цахилгаан шат засварлах |
| 4. | Зураг төсөл, бүрдэл | Зураг төслийн иж бүрдэл:<br>• Цахилгаан шатны зураг<br>• Ажлын төсөв<br>• Тайлан |
| 5. | Ажил гүйцэтгэх үе шат, хугацаа | 1 үе шаттай<br>1. Цахилгаан шатны засварын ажил гүйцэтгэж, хүлээлгэж өгөх. Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно. |
| 6. | Ажил гүйцэтгэх байгууллага | • Холбогдох тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий байгууллага. |
| 7. | Хөрөнгө оруулагч (Захиалагч} байгууллага | Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газар |
| 8. | Техникийн шаардлага | Улаанбаатар лифт НӨҮГ-аас боловсруулсан цахилгаан шатны техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэнэ.<br>1. Лифтний засварын ажлыг гүйцэтгэхдээ ЗТБХБ сайдын 2008 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм" –ийг баримтална.<br>2. Лифтийг засварласны дараа ашиглалтад өгөхийн өмнө туршилтын ажлыг явуулахдаа захиалагч, ашиглалтын байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагуудын төлөөлөгчдийг байлцуулан гүйцэтгэнэ.<br>3. Лифтийг засварлах үе шатны ажил эхлэх дуусах бүрд захиалагч байгууллагыг байлцуулан шалгуулж шаардлага хангасан тухай акт үйлдсэний дараа цаашид хийх ажлыг үргэлжлүүлнэ.<br>4. Лифтний хонгилын хэсгийн барилгын үндсэн хийц эдлэлд өөрчлөлт оруулах, хучилтын хавтанд нэмэлт ачаалал өгөх, төхөөрөмж угсрах зорилгоор эвдэж гэмтээхийг хориглоно.<br>5. Зорчигчийн бүхээг болон жижүүрийн өрөө, машины өрөөний хоорондх холбогдох телефон холбоотой байна. |
| 9. | Ажлын зохион байгуулалт | 1. Нийлүүлэгч дараах зүйлийг ажлын төлөвлөгөөнд тусган захиалагчид ирүүлнэ. Үүнд:<br>• Гүйцэтгэх ажлын нарийвчилсан график; |

| | | |
|---|---|---|
| | | • Ажлын талбайг бэлтгэх;<br>• Бараа нийлүүлэх график;<br>• Ажлын талбай дээр барааг буулгах;<br>• Хуучин сэлбэг хэрэгслийг буулгах;<br>• Шинээр ирсэн сэлбэг хэрэгслийг угсрах;<br>2. Нийлүүлэгч байгууллага нийлүүлэх барааны тодорхойлолт, техникийн шаардлага, түүний дагалдах болон ашиглалтын явцад хэрэглэгдэх хэмжих хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийн нэршил зэргийг Монгол хэл дээр орчуулан захиалагчид хүлээлгэн өгнө.<br>3. Техникийн паспортад ажлын зураг, схем, гагнуур, суурь, далд ажил, газардуулгын зэрэг актуудыг бүрдүүлж, Монгол хэл дээр орчуулан лифт ашиглагч байгууллагад хүлээлгэж өгнө.<br>4. Лифтийг нийлүүлэгч угсрах байгууллага ажил эхлэх зөвшөөрлийг бараа нийлүүлэгдсэнээс хойш ажлын хоногийн дотор авсан байна.<br>• Угсарсан шинэ лифтний туршилт тохируулгатай холбогдон гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.<br>• Ажил гүйцэтгэхтэй холбогдуулан авах зөвшөөрлийн асуудлыг нийлүүлэгч буюу гүйцэтгэгч хариуцна.<br>• Нийлүүлэгч үе шатны ажил дууссан нөхцөлд бүрд мэргэжлийн байгууллагын төлөөлөгчдийг байлцуулан угсралтын байдлыг шалгаж, техникийн магадлал хийж баталгаажуулан ашиглах зөвшөөрөл авна.<br>• Ажлыг гүйцэтгэхэд дагаж мөрдөх норм, дүрмийн дагуу гүйцэтгэнэ.<br>5. Орон сууцны барилгын лифтийг шинээр засварласны дараа ашиглалтад оруулахын өмнө техникийн бүрэн туршилтыг захиалагч, гүйцэтгэгч байгууллага, хяналтын байгууллагуудтай хамтран хийж техникийн дүгнэлт гаргуулна. Туршилт тохируулгын зардлыг гүйцэтгэгч хариуцна.<br>6. Баталгаат хугацаанд ашиглагчийг шаардлагатай сэлбэг хэрэгслээр тасралтгүй хангах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ. |
| 10. | Эдийн засгийн тооцоо, төсөв | • Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох |
| 11. | Ажил гүйцэтгэхэд ашиглах материал | <u>Хууль тогтоомж:</u><br><u>Норм нормативууд:</u><br>• Барилга байгууламжийн галын аюулгүй байдал БНбД 21-02-02/<br>• Лифтний засварын ажлыг гүйцэтгэхдээ ЗТБХБ сайдын 2008 оны 53 дугаар тушаалаар батлагдсан “Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм” –ийг баримтална<br>• Бусад холбогдох норм, дүрэм<br><u>Стандартууд:</u><br>• Цахилгаан шатад тавигдах ерөнхий шаардлага UCS 1502C<br>Бусад холбогдох стандартууд |

ХЯНАСАН:

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга М.Туяа

БОЛОВСРУУЛСАН:

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Т.Цогбадрах

БАТЛАВ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ж.ЛХАГВАСҮРЭН

2024 оны 06 дугаар сарын 11

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 5 ДУГААР ХОРОО, 49/2 ДУГААР БАЙРНЫ ЛИФТ ЗАСВАРЛАХАД ШААРДЛАГАТАЙ СЭЛБЭГИЙН ЖАГСААЛТ

2024 оны 06 дугаар сарын 11 Улаанбаатар хот

1. Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо, 49/2 дугаар байр

| № | Шаардлагатай сэлбэгийн нэр | Тоо хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Ган татлага | 200 м | Шинээр солих |
| 2 | Эх хавтан | 1 ком | Шинээр солих |
| 3 | Башмак | 4 ш | Шинээр солих |
| 4 | Фото мэдрэгч | 1 ш | Шинээр солих |
| 5 | Хүчний кондактор | 8 ш | Шинээр солих |
| 6 | Жижиг кондактор | 4 ш | Шинээр солих |
| 7 | Инвертор | 1 ком | Шинээр солих |
| 8 | Бүхээгний удирдлагын плат | 1 ком | Шинээр солих |
| 9 | Гадна дуудлага | 10 ш | Шинээр солих |
| 10 | Хаалганы удирдлага | 1 ком | Шинээр солих |
| 11 | Редуктор | 1 ком | Шинээр солих |
| 12 | Эх хавтан | 1 ком | Шинээр солих |

ХЯНАСАН:
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА Л.АЛТАНШАГАЙ

БОЛОВСРУУЛСАН:
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Г.ОТГОНТӨГС

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Т.ЦОГБАДРАХ

"ДЭЛГЭРЭХ 49" СӨХ-НЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ч.ЦЭЦЭГМАА